



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/363

Булган сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/39 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган аймгийн Рашаант суманд элсний нүүлтээс сааруулах механик хаалт 8 га талбайд хийх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд

Үнэлгээний хорооны дарга:

- Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд:

- М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

- М.Алтанцэцэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: - Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: - Б.Баярцэнгэл (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

8323018009